



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/150

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн
шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр баг, 2, 3 дугаар байруудын хойд талд байршилтай, иргэн Монгол овогт Баяраагийн Энхтүвшингийн “Автогараж”-ийн зориулалттай 84 м2 газрыг “Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу хавсралтанд батлагдсан 4 иргэнд 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч иргэдэд үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч иргэдтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/182 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын
30-ний өдрийн А/150 дугаар захирамжийн хавсралт

Автогражын зориулалтаар газар эзэмшигч иргэдийн жагсаалт

д/д	Газар эзэмшигчдийн		Газрын		
	Эцэг эх, өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Хэмжээ /м2/	Байршил, хаяг
А	1	2	4	5	6
1	Дайчин овогт Дорж Ариунаа	ЗЮ80062361	Автограж	21	2,3 дугаар байрнуудын хойд талд
2	Боржигин овогт Манлайбаатар Отгонжаргал	ЕЙ89091801	Автограж	21	2,3 дугаар байрнуудын хойд талд
3	Боржигон овогт Манлайбаатар Баянмөнхбат	ЕЙ84072535	Автограж	21	2,3 дугаар байрнуудын хойд талд
4	Боржигон овогт Цогтбаатар Ариунаа	ЕВ87121901	Автограж	21	2,3 дугаар байрнуудын хойд талд